

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Ёс зүйн дэд хорооны гишүүн томилох тухай” 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/241 дугаартай тушаалаар Тамгын газрын төсөл, хөтөлбөр хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн О.Өлзийбат, Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газрын ахлах мэргэжилтэн Г.Хүчитбаатар нар нь Ёс зүйн дэд хорооны гишүүнээр нөхөн томилогдсоноор байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь:

-Ёс зүйн дэд хорооны даргаар Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газрын дарга С.Оюунгэрэл,

-Гишүүдээр Хууль зүй, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Э.Ганбат, Тамгын газрын ахлах мэргэжилтэн Б.Должинсүрэн, төсөл, хөтөлбөр хамтын ажиллагаа хариуцсан ахлах О.Өлзийбат, Иргэний улсын бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч Б.Отгон, Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газрын ахлах мэргэжилтэн Г.Хүчитбаатар,

-Нарийн бичгийн даргаар Хууль зүй, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн Э.Батцэнгэл нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030 он/-ийг баталсантай уялдуулан тус хорооноос “Улсын бүртгэлийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын 2025 оны төлөвлөгөө”-г боловсруулж, батлан 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар баталж аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн бөгөөд уг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

1.Засгийн газрын 2024 оны 109 дугаартай тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г таниулах зорилгоор дуу, дүрс бүхий танилцуулга, мэдээлэл бэлтгэж байгууллагын сайтад 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр байршуулсан.

2.Улсын бүртгэлийн байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдад зориулан сургалт зохион байгуулах Удирдамжийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 06, 03 дугаар сарын 24, 09 дүгээр сарын 22-ны өдрүүдэд нийт 39 шинэ албан хаагчдад “Төрийн албан хаагчийн харилцаа, төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн зөрчлийн хэлбэрүүд” сэдвээр тус хорооны нарийн бичгийн дарга, гишүүд 3 удаагийн сургалтыг хийсэн.

3.2025 оны 2 дугаар улирлын байдлаар "Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төв"-д ирүүлсэн албан хаагчдын ёс зүйтэй холбогдолтой 20 гомдлын шийдвэрлэлтийг зохих журмын дагуу шийдвэрлэсэн эсэхэд хяналт тавин шалгаж, гомдлын шийдвэрлэлтийн байдалд дүгнэлт хийж 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцсэн. Дээрх гомдлоос 6 гомдлыг үндэслэлгүйгээр хааж шийдвэрлэсэн нэгжүүдэд холбогдох мэдээлэл, зөвлөмжийг хүргүүлсэн.

4.Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журмыг баримталдаг, удирдлага, хамт олны эерэг хандлага, харилцаанд анхаардаг хамт олныг шалгаруулах

зорилготой 2025 оны Ёс зүйтэй хамт олныг шалгаруулах удирдамжийг 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдөр батлуулан аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст болон зохион байгуулалтын нэгжүүдэд 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлсэн. Удирдамжид зааснаар 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр дотор нэгжүүдээс тайлан мэдээллийг хүлээн авч нэгтгэж, дүгнэсний дагуу 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Ёс зүйн дэд хорооны №15 дахь хурлаар Ёс зүйтэй хамт олныг шалгаруулж ажилласан.

5.Дэд хорооны зүгээс дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст ажиллах удирдамжийг батлан ажилласан бөгөөд Ёс зүйн дэд хорооны дарга С.Оюунгэрэл, гишүүн Б.Должинсүрэн, Б.Отгон, Э.Батцэнгэл, нарийн бичгийн дарга Э.Сувд-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй 2025 оны 08 дугаар сарын 08, 22-ны өдрүүдэд Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст ажиллаж, ёс зүйн зөрчил, анхаарах асуудлын хүрээнд сургалтыг зохион байгууллаа. Сургалт, мэдээллийн хүрээнд хэлтсийн удирдлагатай уулзаж, ёс зүйн манлайллын талаар болон нэгжийн хэмжээнд нөлөөллийн ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа тухай мэдээлэл солилцож, нийт 39 албан хаагчийг хамруулан хамт олны дунд эерэг уур амьсгалыг бүрдүүлэхэд юуг анхаарах талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, “Улсын бүртгэлийн байгууллагын соёл, ёс зүйн үнэт зүйл”-ийг танилцуулсан. Мөн үйлчилгээний танхимд улсын бүртгэлийн үйлчилгээ авч буй иргэдээс “Улсын бүртгэлийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын талаарх иргэдийн үнэлгээний судалгаа”-г авсан бөгөөд судалгаанд нийт 41 иргэн оролцсон байна.

6.Монгол Улсын Ёс зүйн хорооноос Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”(2024-2030)-ийн холбогдох арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр 1/10656 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

7.Албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Монгол Шведийн хамтын нийгэмлэг" төрийн бус байгууллагын дэргэдэх "Сэтгэл зүйн сургалт, хөдөлгөөнт дасгалын Д&С төв"-тэй хамтран "Албан хаагчдын харилцаа, хандлага" сэдвээр үе шаттай сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. Эхний сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулалтын нэгжийн 40 албан хаагчийн дунд зохион байгуулсан бол 2025 оны 10 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд Сүхбаатар, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн нийт 70 албан хаагчийг хамруулан сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтаар хувь хүнд шаардагдах хэрэгцээт сэтгэл зүйн мэдээллийг өгч, өөрөө өөрийгөө танин мэдэх, аливаа зүйлийг эерэгээр харахад туслах, сэтгэл зүй эерэг байснаараа харилцаа, хандлагад хэрхэн нөлөөлдөг талаарх мэдээллийг өгсөн.

8.Тайлант хугацаанд тус хороо нь 15 удаа хуралдаж, ёс зүйн зөрчилтэй гэх 22 гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэж Ёс зүйн зөрчилд тооцох тухай 9, тооцохгүй тухай 11 дүгнэлтийг гаргаж, албажуулан Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 6.18-д заасны дагуу томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж ажилласан бөгөөд 1 гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай

хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасны дагуу өргөдөл, гомдлоосоо татгалзаж буцаан авсан.

9.Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулж буй үйл ажиллагааны талаар болон хүлээн авсан гомдол, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудаст тухай бүр байршуулсан.

10.Ёс зүйн хорооны 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 13 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх бүртгэлийн маягт”, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 1/14782 дугаартай албан бичгээр хүргүүлж ажиллав.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО